



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/68

Масдалговь

Г Тусгай зөвшөөрлийн эрх сунгах, Г
олгох тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын татварын албанд бүртгэлтэй "Мөнхдэлгэрэх Оюу" ХХК-ны "Бумбаалай", "Галтай зэт" ХХК-ны "Сувд", Дэлгэрхангай сумын "Өндөр ханги" ХХК-ны хүнсний дэлгүүрт согтууруулах ундаа худалдах, "Силвер кров" ХХК-ны "Отог" лаунжид согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 22-ны өдөр хүртэл хугацаагаар олгосугай.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн эрх олгогдсон "Бумбаалай", "Сувд", хүнсний дэлгүүр, "Силвер кров" ХХК-ны "Отог" лаунжийн ажиллах цагийн хуваарийн 09.00 - 24.00 цаг, Дэлгэрхангай сумын "Өндөр ханги" ХХК-ны хүнсний дэлгүүрийн цагийн хуваарийг 09.00 – 20.00 цаг хүртэл хугацаагаар тус тус баталсугай.

Гурав. Тусгай зөвшөөрлийн эрхийг олгосон шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /М.Ганбаатар/, Татварын хэлтэс /М.Туяацэцэг/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О. БАТ-ЭРДЭНЭ



9299217